



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 06 сарын 14 өдөр

Дугаар 316

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.6, 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Харилцаа холбооны зохицуулах хорооны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 233,982,198.67 (хоёр зуун гучин гурван сая есөн зуун наян хоёр мянга нэг зуун ерэн найман төгрөг жаран долоон мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 25,000,000.00 (хорин таван сая) төгрөгөөр шинэчлэн тогтоож, хавсралтад заасны дагуу "Завхан АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга Г.Чинзориг, "Завхан АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал Г.Баттулга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

137005601
16-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2023 оны... дугаар сарын... өдрийн
 316 дугаар тогтоолын хавсралт

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАХ,
 ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ, "ЗАВХАН АЗЗА" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ
 АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шилжүүлэн авах байгууллага	Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөг)	Цаашид ашиглах жил
1	Ланд-Круйзер 70, 4989 УБЧ, арлын дугаар JTERB71J5000404 91	2009	233,982,198.67	"Завхан АЗЗА" төрийн өмчит хувьцаат компани	25,000,000.00	3
	Нийт дүн		233,982,198.67 (хоёр зуун гучин гурван сая есөн зуун наян хоёр мянга нэг зуун ерэн найман төгрөг жаран долоон мөнгө)		25,000,000.00 (хорин сая)	